# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр Дугаар 511 Улаанбаатар хот

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын
2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр хангаж биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг бууруулах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0001049

D:\Huraldaanii material\2019 on\2019.12.10 №24.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
5.11........... тогтоолын 1 дүгээр хавсралт

## "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
## 2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

| Д/д | Үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Х/н | 2018 он | | 2019 он | | 2020 оны төлөвлөгөөний төсөл | 2020 оны төл.төслийг 2019 оны ХБГ-тэй харьцуулбал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | ХБГ | | + / - | % |
| 1 | Хүдэр олборлолт | мян.тн | 36,000 | 36,600 | 36,000 | 37,200 | 36,200 | -1,000 | -2.7% |
| 2 | Хүдэр боловсруулалт | мян.тн | 31,000 | 31,520 | 31,500 | 32,196 | 32,000 | -196 | -0.6% |
| 3 | Баяжмалын үйлдвэрлэлт: | | | | | | | | |
| 3.1 | Зэсийн баяжмал | тн | 571,261 | 585,980 | 576,069 | 587,101 | 569,242 | -17,859 | -3.0% |
| 3.2 | Молибдены баяжмал | тн | 4,855 | 5,486 | 4,902 | 5,061 | 4,721 | -341 | -6.7% |
| **4** | **Нийт орлого** | **сая.төг** | **1,928,945.4** | **2,084,515.9** | **1,958,492.3** | **1,991,145.0** | **1,903,925.6** | -87,219.4 | -4.4% |
| **5** | **Нийт зардал** | **сая.төг** | **1,395,509.3** | **1,466,952.0** | **1,527,297.0** | **1,489,182.9** | **1,616,701.1** | 127,518.1 | 8.6% |
| **6** | **Цэвэр ашиг** | **сая.төг** | **320,864.8** | **439,858.1** | **297,931.0** | **352,013.1** | **192,487.1** | -159,526.0 | -45.3% |
| **7** | **Төсвийн төлбөрт нийт дүн** | **сая.төг** | **629,175.6** | **654,864.5** | **629,798.7** | **785,828.2** | **586,980.3** | -198,847.9 | -25.3% |
| 8 | Төрийн өмчийн ногдол ашиг | сая.төг | | | 150,000.0 | 150,000.0 | 150,000.0 | 0.0 | 0.0% |
| 9 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 6,196 | 6,077 | 6,586 | 6,586 | 6,586 | 0.0 | 0.0% |
| 10 | Нийт цалингийн сан | сая.төг | 183,311 | 183,290 | 221,482 | 217,891 | 274,898 | 57,007.4 | 26.2% |
| 11 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мөнгө | 68.43 | 65.53 | 73.69 | 70.90 | 78.26 | 7.36 | 10.4% |
| 12 | Хөрөнгө оруулалт | сая.төг | 461,702.4 | 259,762.3 | 537,927 | 434,988.0 | 830,680.4 | 395,692.4 | 91.0% |
| 13 | Нийт авлага | сая.төг | | 204,337.0 | 219,267.0 | 149,998.4 | 162,581.8 | 12,583.4 | 8.4% |
| 14 | Нийт өглөг | сая.төг | | 880,644.6 | 416,628.4 | 368,423.1 | 670,991.1 | 302,568.0 | 82.1% |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын ..10..-ны өдрийн
.....511..... тогтоолын 2 дугаар хавсралт

## "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУД | Санхүүжилт /сая.төгрөгөөр/ | | |
|---|---|---|---|---|
| | | 2019 оноос шилжих ажлууд | 2020 онд шинээр төлөвлөсөн ажлууд | Нийт |
| 1 | Барилгын их засвар, шинэ тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт, суурилуулалтын ажил | 23,271.3 | 113,632.2 | 136,903.5 |
| 2 | Үйлдвэрлэлийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангах шаардлагаар хийгдэх төслүүд | - | 249,993.0 | 249,993.0 |
| 3 | Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх төслүүд | - | 86,967.0 | 86,967.0 |
| 4 | Үндсэн хөрөнгийн шинэчлэл | 9,450.0 | 136,265.0 | 145,715.0 |
| 5 | Шинээр худалдан авах үндсэн хөрөнгө | 6,750.0 | 66,300.1 | 73,050.1 |
| 6 | Техник, тоног төхөөрөмжийн их засварын ажил | 2,160.0 | 37,804.1 | 39,964.1 |
| 7 | Геологи, эрэл хайгуулын ажил | 2,817.2 | 21,311.9 | 24,129.1 |
| 8 | Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах болон өргөтгөл шинэчлэлийн төслүүдтэй холбоотой ажлууд | 59,232.6 | 14,725.0 | 73,957.6 |
| | **НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **103,681.1** | **726,998.3** | **830,679.4** |

/долларын ханш-2700 төгрөг/